



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2023 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/20

Улаанбаатар хот

Нийцлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаартай “Эрх, үүрэг шилжүүлэх тухай” тушаалын 5 дугаар хавсралт, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын (НТАГ-2023/30-11-ШТА-НА) тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, дүнг 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн дотор хариу мэдэгдэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч (Д.Сумъяабазар)-д зөвлөсүгэй.

3. Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж, үр дүнг 2024 оны 3 дугаар сарын 15-ны дотор гаргаж танилцуулахыг гүйцэтгэл-нийцлийн аудитын хэлтэс (Э.Мөнхмандах)-т үүрэг болгосугай.

4. Тайланг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Дүүргүүдийн Засаг дарга, Нийслэлийн Байгаль Орчны газар, Нийслэлийн Татварын газарт тус тус хүргүүлсүгэй.



М.ЭРДЭНЭЖАРГАЛ



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР





НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг үндэслэлгүй төлөвлөсөн, орлогын тодорхой хувийг байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулаагүй, хуулийн зарим зүйл, заалт холбогдох бусад хууль журамтай нийцээгүй, хуулийн талаарх ойлголт дутмаг, хэрэгжилт хангалтгүй байна.



АУДИТЫН СЭДЭВ: БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Улаанбаатар хот
2023 он

Аудитын тайланг бэлтгэсэн:	Товчилсон үг	2
Нийслэл дэх Төрийн аудитын газар Гүйцэтгэл-Нийцлийн аудитын хэлтэс	Хүснэгтийн жагсаалт	3
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	4
Хэлтсийн дарга:		
 Э.Мөнхмандах	Бүлэг А. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан уу?	6
Аудитын менежер:	А1. Монгол Улсын хөгжлийн бодлогын урт, дунд болон богино хугацааны баримт бичигт ногоон хөгжлийн талаар дэвшүүлсэн арга хэмжээ үр дүнтэй хэрэгжиж байна уу?	6-8
Ахлах аудитор:		
 Ж.Жавзанпагма	А2. Эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэлийн төлөвлөгөө, гэрээнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж, дүгнэсэн байна уу?	8-9
Аудитор:  М.Одгэрэл	Бүлэг Б. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлт, зарцуулалт хууль, журмын дагуу хэрэгжиж байна уу?	10
 Б.Батбилгүүн		
 О.Оргил	Б1.Төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлт хуулийн дагуу хэрэгжиж байна уу?	10-14
Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, Соёлын Төв өргөө "Г" корпус, Утас: 327787	Б.2 Төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалт хуулийн дагуу хэрэгжиж байна уу?	14-16
Тайланг НТАГ-ын http://audit.mn/ веб сайтаас үзнэ үү.	Бүлэг В. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийн, нөхцөл байдалд тохирох арга хэмжээ авч байна уу?	17
	В.1. Хуулийн хэрэгжилтийн тайлагнал, мэдээллийн сан үнэн зөв илэрхийлэгдэж, төрийн байгууллагуудын уялдаа холбоо оновчтой байна уу?	17-18
	В.2. Хуулийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээг хийж үр дүнг дүгнэсэн үү?	19-20
	Аудитын дүгнэлт	21
	Аудитын зөвлөмж	22-23

Товчилсон үг

АДБОУС	АУДИТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГУУДЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БХД	Багахангай дүүрэг
БНАТ	Байгалийн нөөц ашигласны төлбөр
БНД	Багануур дүүрэг
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОНХС	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд
ГЗБГЗЗГ	Газар зохион байгуулалт, геодези зурагзүйн газар
ЗГ	Засгийн газар
ЗД	Засаг дарга
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НД	Налайх дүүрэг
НЗД	Нийслэлийн засаг дарга
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НБОГ	Нийслэлийн Байгаль орчны газар
НТГ	Нийслэлийн Татварын газар
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТУНС	Татварын удирдлагын нэгдсэн систем
СХД	Сонгинохайрхан дүүрэг
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХАА	Хөдөө аж ахуй
ХБТХ	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ХУД	Хан-Уул дүүрэг
ЧД	Чингэлтэй дүүрэг

Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Хүснэгт 1	Газрын нэгдмэл сангийн ангиллын тайлан	5
Хүснэгт 2	Усны нөөц ашигласны орлогын бүрдүүлэлт	12-13
Хүснэгт 3	Ус ашиглах дүгнэлт, зөвшөөрөл олгосон иргэн ААНБ-ын мэдээлэл	14
Хүснэгт 4	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	15
Хүснэгт 5	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөлт	16
Хүснэгт 6	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулсан төсөв	17
Хүснэгт 7	Байгаль, хамгаалах нөхөн сэргээхээр хуулийн дагуу зарцуулах хувийг дүүргийн төсвийн нийт орлоготой харьцуулсан байдал	18

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл: Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2023 оны А/04 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аудитыг гүйцэтгэв.
Аудитын зорилт	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд чиглэгдсэн. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. Үүнд: ✚ А. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан уу? ✚ Б. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлт, зарцуулалт хууль, журмын дагуу хэрэгжиж байна уу? ✚ В. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийн, нөхцөл байдалд тохирох арга хэмжээ авч байна уу?
Аудитын хамарсан хүрээ	Аудитыг Нийслэл, дүүргийн ИТХ, Нийслэл, дүүргийн ЗДТГ, НБОГ, НТГ, дүүргүүдийн Татварын хэлтэс болон холбогдох бусад газруудыг хамруулан гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000 үндэслэн боловсруулсан гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, асуулга, судалгаа авах, мэдээ, тайланг судалж, нөхцөл байдлын шинжилгээ хийх зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, ажлын баримт боловсруулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Гүйцэтгэл-нийцлийн аудитын хэлтсийн дарга, аудитын менежер Э.Мөнхмандах, аудитын менежер Б.Номинбаатар нар хянан удирдаж, аудитын багийг ахлах аудитор Ж.Жавзанпагма ахалж, аудитор М.Одгэрэл, О.Оргил, Б.Батбилгүүн нар гүйцэтгэв. Аудитыг 2023 оны 5 дугаар сарын 2-ны өдрөөс 2023 оны 6 дугаар сарын 7-ны өдрийг хүртэл гүйцэтгэв.

Ерөнхий мэдээлэл:

Нийслэл Улаанбаатар хот 470444 га нутаг дэвсгэртэй бөгөөд үүнээс ХАА-н газар 48.7%, хот тосгон бусад суурины газар 16.1%, зам шугам сүлжээний газар 1.4%, ойн сан бүхий газар 15.7%, усны сан бүхий газар 0.9%, улсын тусгай хэрэгцээний газар 17.2%-ийг тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ №1 ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН АНГИЛЛЫН ТАЙЛАН

Д/Д	Дүүрэг нэр	Нийт газар	Үүнээс газрын ангиллын төрлөөр					
			Хөдөө аж ахуйн газар	Хот, тосгон бусад суурины газар	Зам, шугам сүлжээний газар	Ойн сан бүхий газар	Усны сан бүхий газар	Улсын тусгай хэрэгцээний газар
1	БГД	2949.0	490.14	1698.66	181.04	0.00	576.20	2.96
2	БЗД	124412.0	50250.50	7983.44	1035.13	34720.52	2315.9	28106.52
3	ЧД	8930.0	776.70	3444.50	120.16	203.31	6.00	4379.33
4	СБД	20840.0	3398.11	3808.38	173.62	13397.75	35.09	27.05
5	СХД	120063.0	82009.81	13950.85	1517.38	21420.69	71.00	1093.27
6	ХУД	48466.0	21681.45	7819.92	1089.77	2115.99	975.00	14783.86
7	БНД	62020.0	38620.19	21965.25	805.28	508.76	94.00	26.51
8	БХД	14000.0	11062.28	2534.43	402.39	0.00	0.00	0.90
9	НД	68764.0	20823.00	12752.44	1047.04	1668.55	5.00	32467.98
НИЙТ ДҮН		470444.0	229112.18	75957.86	6371.82	74035.58	4078.19	80888.38

Эх сурвалж: НГЗБА-ны 2023 оны Газрын нэгдмэл сангийн тайлангаас

Нийслэлийн нутаг дэвсгэрийн 64653.63 га буюу 87.3% ой, усны сан бүхий газрын 3936.1 га буюу 96.5%-ийг гол мөрөн, 38.0 га буюу 9%-ийг нуур, цөөрөм, тойром, 104.09 га буюу 2.6%-ийг горхи, булаг, шанд эзэлж байна.

БҮЛЭГ А. БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАГДСАН УУ?

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдээгүй, холбогдох хууль, журам хоорондоо нийцээгүй, хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтны чиг үүрэг давхардсан, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангалтгүй байна.

А1. Монгол Улсын хөгжлийн бодлогын урт, дунд болон богино хугацааны баримт бичигт ногоон хөгжлийн талаар дэвшүүлсэн арга хэмжээ үр дүнтэй хэрэгжиж байна уу?

Нийслэлд ногоон хөгжлийн талаар дэвшүүлсэн зорилт арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.

А1.1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль нь холбогдох хууль тогтоомж, бусад эрх зүйн акттай нийцэж байна уу?

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-23.3¹-т сум, дүүргийн засаг дарга байгалийн нөөцийн төлбөр хураах эрх бүхий албан тушаалтныг томилж орлогыг бэлнээр хураан авч орон нутгийн төсөвт тушаах харилцааг тусгажээ. Дээрх хуулийн дагуу дүүргүүдэд байгалийн нөөцийн төлбөр хураах эрх бүхий албан тушаалтан томилогдоогүй байна.

Төрөлжсөн хуулиудад байгалийн нөөцийн төлбөрийн орлогыг төлөвлөх, ногдуулах, тайлагнах харилцааг нарийвчлан тусгаж хуульчилжээ. Тухайлбал:

- Газрын төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйл “Газрын төлбөрийг төлөх, тайлагнах” -ийн 10.3², 10.4³ -т Газрын төлбөрийн асуудал эрхэлсэн байгууллага /албан тушаалтан/ газрын төлбөрийн ногдуулалтыг хийж, татварын албанд хүргүүлэх, татварын алба ногдуулалт төлөвлөлтөд хяналт тавихаар; / [Энэ хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан](#)
- Усны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2⁴-т ус ашигласны төлбөрийг дүүргийн байгаль хамгаалагч ногдуулж, төлөлтөд хяналт тавих;
- ЗГ-ын 2013 оны 326 дугаар “Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай журам”-ын тайлбар хэсэгт ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэний ашигласны усны төлбөрийг усаар хангагч байгууллага тооцож авна;

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн байгалийн нөөц ашигласны төлбөр ногдуулах, хураах, тайлагнах хэсэг нь дараах хуулиуд болон холбогдох журамтай нийцэхгүй нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1⁵-д заасан урьдчилсан судалгааг дутуу хийж бусад хууль тогтоомжтой нийцүүлээгүй холбоотой байна.

¹ 23.1. Сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөр хураах эрх бүхий албан тушаалтныг томилон ажиллуулна.
23.2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг дараа сарын 10-ны өдрийн дотор орон нутгийн төсөвт төлж, төлбөрийн жилийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор харьяалагдах татварын албанд тушааж эцсийн тооцоо хийнэ.
23.3. Сум, дүүргийн Засаг даргын томилсон төлбөр хураах эрх бүхий албан тушаалтан төлбөрийг бэлнээр хураан авсан тухай бүр сум, дүүргийн төсөвт тушаана.

² 3. Газрын төлбөрийн асуудал эрхэлсэн байгууллага /албан тушаалтан/ газрын төлбөрийн ногдуулалтын жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд тушааж, ногдуулалтын эцсийн тооцоог хийнэ.

³ 4. Татварын алба Татварын ерөнхий хуулийн дагуу газрын төлбөрийн ногдуулалт, төлөлтөд хяналт тавина.

⁴ 19.1.2. ус ашигласны болон бохирдуулсны төлбөрийг хууль тогтоомжийн дагуу ногдуулж, төлөлтөд хяналт тавих;

⁵ 13.2.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуульд нийцэх эсэхийг судлах;

Дүгнэлт: Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн зарим зүйл, заалт нь холбогдох хууль болон журамтай нийцээгүй байна.

А1.2. Монгол Улсын хөгжлийн бодлогын урт, дунд болон богино хугацааны баримт бичгийг баталж, тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт хангагдаж байна уу?

Монгол Улсын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд ногоон хөгжил, байгалийн нөөц, байгаль хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой дараах зорилт арга хэмжээг тусгасан байна. Үүнд:

- Алсын хараа-2050 урт хугацааны баримт бичигт 3 зорилт 10 арга хэмжээ; /Байгалийн баялгийн үр өгөөж чиглэлээр 1 зорилт 3 арга хэмжээ, үнэт баялаг ус чиглэлээр 1 зорилт 4 арга хэмжээ, орчин төвтэй шийдэл чиглэлээр 1 зорилт 3 арга хэмжээ/
- МОНГОЛ УЛС-ын ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 1 зорилт 12 арга хэмжээ;
- Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд чиглэлээр 3 зорилт 11 арга хэмжээг тус тус баталсан байна.

Нийслэлийн Хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд ногоон хөгжил, байгалийн нөөц, байгаль хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ тусгаагүй байна.

Дээрх бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан ногоон хөгжил, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой, зорилт арга хэмжээний хэрэгжилт хангагдсан эсэх талаар судлахад дараах байдалтай байна.

Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт байгаль хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхтэй холбоотой НБОГ хэрэгжүүлэх 6 зорилт 13 арга хэмжээг тусгаж хэрэгжүүлснээс бүрэн хэрэгжиж дууссан 8, хэрэгжилт дутуу 5, хэрэгжээгүй 1 арга хэмжээ байна.

Хэрэгжээгүй арга хэмжээний талаар:

НЗД-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.3.4.2-т СХД-ийн Баянголын ам, БНД-ийн усны нөөцийн судалгааны ажлыг хийнэ” арга хэмжээний хүрээнд ус хангамжийн хайгуул, судалгааны ажлыг хийхээр тусгасан ч хөрөнгө шийдвэрлэгдээгүй шалтгаанаар хэрэгжээгүй байна.

Дүүргийн ЗД нар Монгол Улсыг хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны баримт бичиг Алсын хараа 2050, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлүүдэд нийцүүлэн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнүүдэд ногоон хөгжлийн талаар арга хэмжээ төлөвлөж харин байгалийн нөөц баялаг ашиглах, түүний орлогоос байгаль хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой харилцааг төлөвлөж, хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3⁶, 5.1.4⁷-д заасан хөгжлийн бодлого төлөвлөлтөд баримтлах нэгдмэл, цогц, харилцан уялдаатай, тогтвортой, тасралтгүй, залгамж чанартай байх зарчмыг баримтлаагүйтэй холбоотой байна.

⁶ 5.1.3.нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх;

⁷ 5.1.4.тогтвортой, тасралтгүй, залгамж чанартай байх;

Дүгнэлт: Нийслэл Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулж батлахдаа ногоон хөгжлийн бодлогыг тусгасан ч хэрэгжилт хангалтгүй байна.

A1.3. Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхтэй холбогдуулан менежментийн төлөвлөгөөг баталж хэрэгжүүлсэн үү?

БОНХСайдын 2012 оны А/102 дугаар тушаалаар баталсан усны нөөцийн менежментийн төлөвлөгөөг Туул голын сав газрын захиргаа 2012-2016, 2016-2021 онуудад 2 үе шаттайгаар хэрэгжүүлж дууссан байна.

Мөн НБОГ-аас ойн менежментийн төлөвлөгөөг 2019-2023 онд хэрэгжүүлэхээр боловсруулж Ойн нөөцийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2018 оны 12 дугаар сарын 18-ны өдөр батлуулсан байна. хурлаар баталж 2019-2023 онд хэрэгжүүлэхээр батлуулсан байна. Харин байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх болон ургамал, амьтныг хамгаалах нөхөн сэргээх чиглэлд менежментийн төлөвлөгөө боловсруулж, батлуулаагүй байна.

Дүүргүүдэд 2021, 2022 онуудад байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх чиглэлээр менежментийн төлөвлөгөөг боловсруулж мөрдөөгүй байна.

Дүгнэлт: Дүүргүүд байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхтэй холбогдуулан менежментийн төлөвлөгөөг баталж хэрэгжүүлээгүй байна.

A2. Эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэлийн төлөвлөгөө, гэрээнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж, дүгнэсэн байна уу ?

Эрх бүхий албан тушаалтнуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж, дүгнээгүй байна.

A2.1.БОАЖ-ын Сайд, Аймаг, НЗД, харьяа төсөв захирагчтай байгуулсан гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж, дүгнэсэн байна уу?

БОАЖСайд болон НЗД-ын хооронд 2021 онд №21-22, 2022 онд №22-22 дугаар бүхий “Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах” гэрээг байгуулж тухайн онуудад хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсан байна. Дээрх гэрээнүүдэд НЗД байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбоотой 2 чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

- Гэрээний 4.3-т “Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, ЗГ-ын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.1-3.4 дэх заалтын дагуу олсон орлогыг зөвхөн хууль тогтоомжид заасан зориулалтын дагуу зарцуулах”;
- Гэрээний 4.4-т “2021 онд орон нутгийн төсөвт төвлөрсөн 731.8 сая төгрөг, 2022 онд нийслэлийн төсөвт төвлөрсөн байгалийн нөөц ашигласан орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд зарцуулах” гэж тус тус заасан байна.

Гэрээний хэрэгжилтийн дээрх заалтыг дараах байдлаар тайлагнасан байна.

- ИТХ-аас газар хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулахаар 2021 онд 1,481.9 сая төгрөг, 2022 онд 1,391.8 сая төгрөг нийт 2,873.7 сая төгрөгийг байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулахаар баталж

гэрээнд тусгасны дагуу 2021 оны тайланд “750.3 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан гэх боловч Багануур дүүргийг ус хангамжийн эх үүсвэрийн усны нөөцийн хайгуул судалгаа хийсэн” гэснээс бусад ажил тодорхойгүй;

- 2022 оны тайланд “ЗГ-ын 2020 оны 184 дугаар “Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж, ашигласны төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын дагуу 314 иргэнд 7,436.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн” гэснээс өөрөөр тайлагнаагүй байна.

НБОГ гэрээний хэрэгжилтийг тайлагнахдаа нийслэлийн хэмжээнд нэгтгээгүй, хийсэн ажлыг тоон үзүүлэлтгүй ерөнхий байдлаар хангалтгүй тайлагнасан байна.

Иймд аудитаар НБОГ-т байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг хууль, журамд заасан төрөл тус бүрээр бүрдүүлэх, хуульд заасан зохих хувийг байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулж тайлагнахдаа дүүрэг тус бүрээр хийсэн ажлыг тодорхой бичиж нийслэлийн хэмжээнд нэгтгэн тайлагнаж байх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Дүгнэлт: БОАЖСайд болон НЗД-ын хооронд байгуулсан гэрээнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан ч хэрэгжилт хангалтгүй, бодитой дүгнээгүй байна.

А2.2.Аймаг, НЗД харьяа төсөв захирагчтай байгуулсан гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж, дүгнэсэн байна уу?

Нийслэл, дүүргүүдийн ЗД-ын хооронд 2021 онд “Засгийн газрын зарим чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэх, НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх гэрээ”, 2022 онд “Хариуцлагын гэрээ”-г тус тус байгуулж, энэхүү гэрээний салшгүй хэсэг нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө байна гэж гэрээнд тусгасан байна.

Иймд Нийслэл, дүүргийн ЗД-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2021-2025 оны хэрэгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, холбогдох байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж, дүгнэсэн эсэхийг тодруулахад дараах байдалтай байна.

НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д байгаль хамгаалах, нөхөн сэргээхээр тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэгч агентлаг болох НБОГ-аар дамжуулан хэрэгжүүлэхээр 2021 онд 1,481.9 сая төгрөг, 2022 онд 1,391.8 сая төгрөгийг тусгажээ. Харин дүүргүүдийн хувьд тухайн жилийн төсөвт тодорхой арга хэмжээг тусгаагүй байна.

Дүүргийн ЗД нар НЗД-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөө баталж тухайн баримт бичгүүдэд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тодорхой тусгаагүй ч байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаатай холбоотой зорилт, төсөл арга хэмжээг “Ногоон хөгжлийн бодлого” дэд хэсэгт тусгажээ.

Дүгнэлт: Нийслэл, дүүргийн засаг даргын хооронд байгуулсан байгуулсан гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаагүй байна.

БҮЛЭГ Б. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛАХ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫН ХЭСГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ХЭРЭГЖИЖ БАЙНА УУ?

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлт нийслэлийн хэмжээнд жилд дунджаар 95.8%-тай байгаа ч тухайн орлогын тодорхой хувийг байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулаагүй, хэрэгжилтийг тайлагнаагүй холбогдох журмыг мөрдөж ажиллаагүй байна.

Б1.Төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлт хуулийн дагуу хэрэгжиж байна уу?

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлт үндэслэлгүй, орлого бүрдүүлэлт хангалтгүй байна.

Б1.1.Монгол Улсын байгалийн нөөцийг тогтоож, ашиглах төрөл, дээд хэмжээг үндэслэлтэй төлөвлөсөн үү?

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2⁸, 15 дугаар зүйлийн 15.5⁹, 19 дүгээр зүйлийн 19.2¹⁰-т тус тус зааснаар аймаг, нийслэлийн ИТХ нь дээрх заалтад хамаарах байгалийн нөөцийн төлбөрийн хувь хэмжээг тогтоож, чөлөөлж, хөнгөлөх эрхтэй бөгөөд байгалийн нөөцийг тогтоох, ашиглах төрөл, дээд хэмжээг төлөвлөх чиг үүрэггүй тул аудитын зорилтод хариулах боломжгүй болно.

Б1.2.Төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцааг журмын дагуу хэрэгжүүлсэн үү?

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1-13.2.5¹¹, ЗГ-ын 2022 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын хоёр¹² дахь заалтуудад байгалийн нөөц ашигласны орлогын төрөл болон төлбөрийн орлого бүрдүүлэх хэсгийг заасан.

Аудитаар байгалийн баялаг ашигласны төлбөрийн орлогыг бүрдүүлэх харилцааг журмын дагуу хэрэгжүүлсэн эсэхийг төрөл тус бүрээр авч үзэхэд Амьтны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.12¹³, Байгалийн ургамлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1¹⁴, Ойн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1¹⁵-д тус тус зааснаар хориглодог учир дүүргүүд төлөвлөлт хийгддэггүй байна.

Нийслэлд усны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 2021 онд 4,561.0 сая төгрөг, 2022 онд 4,859.5 сая төгрөг байхаар төлөвлөсөн байна.

⁸ 14.2.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас энэ хуулийн 14.1-д заасан төлбөрийн хэмжээний хязгаарт багтаан ургамлын нөөц, тархац, ач холбогдол, ашиглагдах эрхтний онцлог, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн байдлыг харгалзан ургамлын нэр төрөл тус бүрээр төлбөрийн хэмжээг тогтооно.

⁹ 15.5.Байгалийн халуун усыг халаалтын зориулалтаар ашиглавал ногдуулах төлбөрийн хэмжээг тухайн орон нутгийн халаалтын хөлсний 50 хүртэл хувиар, үйлчилгээ, аж ахуйн зориулалтаар ашиглавал ус ашигласны төлбөрийн 50 хүртэл хувиар аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоож болно.

¹⁰ 19.2.Элбэг ургамал ашигласны төлбөрийг хөнгөлж болох бөгөөд төлбөрийг хөнгөлөх нөхцөл, болзол, хувь, хэмжээг тухайн орон нутгийн нөхцөл, онцлог байдлыг харгалзан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

¹¹ 13.2.1. байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого; 13.2.2. ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого; 13.2.3. ойн нөөц ашигласны төлбөрийн орлого; 13.2.4. ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого; 13.2.5.газрын нөөцийн төлбөрийн орлого.

¹² Хоёр. Төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх

¹³ 11.1.12.эрх бүхий мэргэжлийн байгууллагаар агнуур зохион байгуулалтын ажлыг хуульд заасан хугацаанд нь хийлгээгүй аймаг, сум, нийслэл, дүүргийн нутагт агнуурын амьтан агнах, барих;

¹⁴ 1/хот, тосгон, бусад суурины ногоон бүс;

¹⁵ 8.5.1.нийслэлийн ногоон бүсэд хамаарах ойн заагийг Засгийн газар;

ХҮСНЭГТ №2 УСНЫ НӨӨЦ АШИГЛАСНЫ ОРЛОГО БҮРДҮҮЛЭЛТ

№	Нийслэл, дүүрэг	2021 он		2022 он		/сая.төг/
		төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	
1	Хотын шууд	4,500.0	2,752.0	4,500.0	2,460.3	
2	БГД	-	7.3	-	6.8	
3	БЗД	-	0.6	253.0	0.0	
4	БНД	24.0	24.0	24.0	24.7	
5	БХД	3.0	2.5	2.0	2.5	
6	СБД	-	1.8	-	-	
7	СХД	4.0	2.0	4.5	4.5	
8	НД	-	0.3	36.0	0.8	
9	ХУД	30.0	39.5	40.0	17.2	
10	ЧД	-	-	-	61.6	
	ДҮН	4,561.0	2,830.1	4,859.5	2,578.5	

2021 онд НБОГ болон БНД, БХД, СХД, ХУД-үүд ус ашигласны төлбөр 4,561.0 сая төгрөгийг төлөвлөж, 2022 онд БЗД 253.0 сая, НД 36.0 сая төгрөгийг нэмж төлөвлөсөн байна. БГД, СБД, ЧД-үүд 2021, 2022 онуудад усны нөөц ашигласны төлбөрөөс орох орлогыг төлөвлөөгүй байна.

Харин НБОГ болон БНД, БХД дүүргүүд ус ашигласны төлбөрийн орлогыг өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөсөн байна.

Усны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.27-д "ус ашиглагч" гэж ашиг олох зорилгоор үйлдвэрлэл, үйлчилгээндээ ус, усан орчин, рашааныг ашигладаг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг" гэж заасан бөгөөд ус ашигласны төлбөрийн орлого бүрдүүлэх харилцаа нь ус ашиглагч иргэн, ААНБ-ын мэдээлэлд үндэслэн төлөвлөхөөр байна.

Усны төлбөрийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4¹⁶, 28.6¹⁷, 29 дүгээр зүйлийн 29.1¹⁸-д заасны дагуу усны сав газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн НБОГ, НБОГ-ын дүгнэлтийг үндэслэн дүүргүүдийн 3Д нар зөвшөөрөл олгож, гэрээ байгуулахаар заасан.

Гэтэл байгууллага хоорондын уялдаагүй ажилласнаас дүгнэлт бүрд гэрээ байгуулаагүй, ус ашиглагч иргэн, ААНБ-ын тоон мэдээлэл тодорхойгүй, төлөвлөгөө батлахдаа гүйцэтгэлд үндэслэн баталсан, дүүргүүдийн төрийн сан, ЗДТГ-т ус ашиглагчийн мэдээлэл байхгүй зэргээс шалтгаалж тулган баталгаажуулалт хийх боломжгүй байна.

Энэ нь зарим дүүргийн 3Д нар ЗГ-ын 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 2.5¹⁹-д заасны дагуу БНАТ-1 маягтаар жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор байгалийн нөөц ашигласны

16 28.4.Хоногт 100 шоо метрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, 50-100 шоо метр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоо метр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана.

17 28.6.Энэ хуулийн 28.4-т заасан дүгнэлтийг үндэслэн ус ашиглах зөвшөөрлийг хоногт 100 шоо метрээс их ус ашиглах тохиолдолд сав газрын захиргаа, хоногт 50-100 шоо метр ус ашиглахад аймаг, нийслэлийн байгаль орчны алба, хоногт 50 шоо метрээс бага ус ашиглахад сум, дүүргийн Засаг дарга олгож, усны мэдээллийн санд бүртгэнэ.

18 29.1.Энэ хуулийн 28.6, 28.7-д заасан зөвшөөрлийг үндэслэн хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрээс хангагдаж байгаа ус ашиглагчтай тухайн ус хангагч байгууллага, төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрээс хангагдаж байгаа ус ашиглагчтай сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны алба, сум, дүүргийн Засаг дарга гэрээ байгуулна.

19 2.5. Сум, дүүргийн Засаг дарга Төсвийн тухай хуулийн 23.8.4, 23.8.6, 23.8.7, 23.8.9, 23.8.14-т заасан орлогын төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-1 маягтын дагуу жил бүрийн 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ.

орлогын төлөвлөгөөний саналаа байгаль орчны асуудал хариуцсан байгууллагад хүргүүлэх чиг үүргээ хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

Нийслэлийн хэмжээнд ан амьтан, ой, ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөдөггүй, газрын нөөц ашиглах харилцаа нь тус хуулиар зохицуулагддаггүй байна.

Дүгнэлт: Нийслэлд төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцааг журмын дагуу хэрэгжүүлээгүй байна.

Б1.3.Байгалийн нөөц ашиглах зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу олгосон уу?

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6-д “Энэ хуулийн 28.4-т заасан дүгнэлтийг үндэслэн ус ашиглах зөвшөөрлийг хоногт 100 шоометрээс их ус ашиглах тохиолдолд сав газрын захиргаа, хоногт 50-100 шоометр ус ашиглахад аймаг, нийслэлийн байгаль орчны алба, хоногт 50 шоометрээс бага ус ашиглахад сум, дүүргийн Засаг дарга олгож, усны мэдээллийн санд бүртгэнэ” гэж заасан.

Усны тухай хуульд зааснаар Туул голын сав газрын захиргаа 2021, 2022 онуудад 50-100 шоо метр ус ашиглах зөвшөөрөл хүссэн 67 иргэн, ААНБ-д ус ашиглах дүгнэлт гаргасны дагуу НБОГ 8 иргэн, ААНБ буюу 11.9%-д гэрээ байгуулсан байна.

ХҮСНЭГТ №2 УС АШИГЛАХ ДҮГНЭЛТ, ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН ИРГЭН ААНБ-ЫН МЭДЭЭЛЭЛ

№	Нийслэл, дүүрэг	2021		2022	
		Сав газрын захиргаа		Сав газрын захиргаа	
		Дүгнэлт гарсан	Гэрээ байгуулсан	Дүгнэлт гарсан	Гэрээ байгуулсан
1	БГД	2	-	5	1
2	БЗД	5	-	7	1
3	БНД	-	-	-	-
4	БХД	-	-	-	-
5	СБД	-	-	-	-
6	СХД	13	-	13	2
7	НД	4	1	4	1
8	ХУД	6	-	8	2
9	ЧД	-	-	-	-
	Дүн	30	1	37	7

Харин Усны төлбөрийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4-т зааснаар НБОГ нь 50 шоо метрээс доош ус ашиглах зөвшөөрөл хүссэн иргэн, ААНБ-д ус ашиглах дүгнэлт гаргасны дагуу дүүргийн ЗД нар ус ашиглах зөвшөөрөл олгож, гэрээ байгуулахаар хуульд заасан. Гэтэл НБОГ-т 2021, 2022 онуудад хэчнээн иргэн, ААНБ-д дүгнэлт гаргасан тоон мэдээлэл байхгүй байна. Ус ашиглах дүгнэлт гаргасан иргэн, ААНБ-ын мэдээлэл байхгүй шалтгаан нөхцөлийг тодруулахад тухайн чиг үүргийг хариуцаж байсан албан тушаалтнууд солигдсон гэх тайлбарыг өгч байна.

Дүүргүүд ус ашиглах дүгнэлтийн дагуу зөвшөөрөл олгож буй эсэхийг тодруулахад Налайх дүүрэг 2021 онд ус ашиглах дүгнэлт гарсан 35 иргэн, ААНБ-аас 17 иргэн, ААНБ-тай, 2022 онд дүгнэлт гарсан 30 иргэн, ААНБ-аас 13 иргэн, ААНБ-тай гэрээ хийсэн байна. Бусад дүүргийн ЗД нар ус ашиглах дүгнэлтийн дагуу зөвшөөрөл олгож, гэрээ байгуулаагүй байна.

Нийслэлийн хэмжээнд НБОГ-аас Байгалийн ургамлын тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, БОАЖСайдын 2020 оны А/677 дугаар тушаалын дагуу уламжлалт анагаах ухаан технологийн хүрээлэнд 2021 онд 50кг, 2022 онд 65кг нийт 115кг эмийн ургамал түүх зөвшөөрлийг журмын дагуу олгосон байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд газрын нөөцийн зөвшөөрлийг ашиглах харилцааг зохицуулдаггүй бөгөөд энэ нь тусгай хуулиар зохицуулагддаг учир аудитад хамруулаагүй хязгаарласан болно.

Дүгнэлт: Нийслэлд усны нөөц ашиглах зөвшөөрлийг хууль, тогтоомжийн дагуу олгоогүй байна.

Б1.4.Байгалийн нөөц ашигласны төлбөрийг үндэслэлтэй төлөвлөж, ногдуулан, бүрэн төвлөрүүлсэн үү?

Нийслэлд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасан байгалийн нөөцийн орлогын төрлүүдээс газар, ус, рашаан, ойн нөөц ашигласны төлбөрийн орлогуудыг төвлөрүүлдэг бөгөөд ургамал, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг төвлөрүүлдэггүй байна.

Нийслэлийн хэмжээнд 2021 онд 105,716.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 90,561.0 сая төгрөг буюу 85.6%, 2022 онд 92,849.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 98,439.6 сая төгрөг буюу 106%-тай төвлөрүүлсэн байна.

ХҮСНЭГТ № 4 БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ

		2021 оны		2022 оны	
Үзүүлэлт		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Нийт	Байгалийн нөөц ашигласны төлбөр	105,716.9	90,561.0	92,849.5	98,439.6
	Газрын төлбөр	101,095.9	87,685.7	87,930.0	95,841.8
	Ус ашигласны төлбөр	4,561.0	2,830.1	4,859.5	2,578.5
	Ойгоос мод ашигласны төлбөр	60.0	45.2	60.0	19.2
Нийслэл	Газрын төлбөр	68,113.2	63,327.8	2,000.0	31,442.9
	Ус ашигласны төлбөр	4,500.0	2,752.0	4,500.0	2,460.3
	Ойгоос мод ашигласны төлбөр	60.0	45.2	60.0	14.8
	Газрын төлбөр	2,250.0	2,728.4	6,159.7	5,948.5
БГД	Ус ашигласны төлбөр	-	7.3	-	6.8
БЗД	Газрын төлбөр	8,900.0	4,491.0	32,000.0	12,222.6
	Ус ашигласны төлбөр	-	0.6	253.0	-
БНД	Газрын төлбөр	637.5	644.4	2,080.0	1,414.9
	Ус ашигласны төлбөр	24.0	24.0	24.0	24.7
БХД	Газрын төлбөр	27.3	26.6	40.7	52.2
	Ус ашигласны төлбөр	3.0	2.5	2.0	2.5
СБД	Газрын төлбөр	570.0	1,362.5	6,160.4	3,489.3
	Ус ашигласны төлбөр	-	1.8	-	-
СХД	Газрын төлбөр	4,522.7	3,465.2	8,928.6	9,317.4
	Ус ашигласны төлбөр	4.0	2.0	4.5	4.5
НД	Газрын төлбөр	950.0	696.4	1,722.0	1,875.0
	Ус ашигласны төлбөр	-	0.3	36.0	0.8
ХУД	Ойгоос мод ашигласны төлбөр	-	-	-	4.4
	Газрын төлбөр	14,418.6	10,361.1	25,317.2	28,406.5
ЧД	Ус ашигласны төлбөр	30.0	39.5	40.0	17.2
	Газрын төлбөр	706.6	582.4	3,521.5	1,672.5
ЧД	Ус ашигласны төлбөр	-	-	-	61.6

Нийслэлд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого бүрдүүлэлтийг хууль, тогтоомжид нийцүүлэн бүрдүүлж буй эсэхийг тодруулахад зөрчлүүд илэрч байна.

БГД нь тайлант онуудын төсвийг батлахдаа Ус ашигласны төлбөрийн орлого төвлөрүүлэхгүйгээр баталсан ч 2021 онд 7.3 сая, 2022 онд 6.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Энэ нь ЗГ-ын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль

орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 4.1²⁰ дах заалтыг зөрчсөн байна.

- БХД нь 2022 онд Ус ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө батлахдаа өмнөх онд төвлөрүүлсэн орлогоос 0.5 сая төгрөгөөр багаар төлөвлөсөн байна.
- НД 2022 онд ойгоос мод ашигласны төлбөрөөс 4.4 сая төгрөгийн орлого олсон ч тухайн оны төсөв батлуулахдаа төлөвлөгөөг батлуулаагүй байна.

Дүгнэлт: Нийслэлийн хэмжээнд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг үндэслэлтэй төлөвлөж, ногдуулаагүй, бүрэн төвлөрүүлсэн эсэх нь тодорхойгүй байна.

Б2. Төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалт хуулийн дагуу хэрэгжиж байна уу?

Нийслэлийн ЗДТГ 2021, 2022 онуудад байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн 19.5%-ийг зарцуулж дүүргүүд төлөвлөж, хэрэгжүүлэхгүй байна.

Б.2.1. Төлбөрийн орлогыг хуульд заасан хувь хэмжээний дагуу менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөж батлуулсан уу?

Нийслэлийн хэмжээнд 2021 онд 90,561.0 сая төгрөг, 2022 онд 98,439.5 сая төгрөг байгалийн нөөцийн орлогоос төвлөрүүлсэн байна. Үүнээс байгалийн нөөцийн төрлөөс хамаарч байгаль хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулах хувь хэмжээг тооцвол 2021 онд 14,181.8 сая төгрөг, 2022 онд 15,295.1 сая төгрөгийг тус тус зарцуулахаар байна.

ХҮСНЭГТ № 5 БАЙГАЛЬ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ

/сая.төг/

	Нийслэл, дүүрэг	2021 он			2022 он		
		Нийт орлого	Хуулиар зарцуулах хэмжээ	Төлөвлөж батлуулсан хэмжээ	Нийт орлого	Хуулиар зарцуулах хэмжээ	Төлөвлөж батлуулсан хэмжээ
1	Нийслэл	66,125.0	10,500.8	1,481.9	33,918.1	5,590.2	1,391.8
2	БГД	2,735.6	411.8	-	5,955.3	894.6	-
3	БЗД	4,491.7	673.9	-	12,222.7	1,833.4	-
4	ХУД	10,400.7	1,568.0	-	28,423.7	4,267.0	-
5	СБД	1,364.3	205.0	-	3,489.3	523.4	-
6	ЧД	582.4	87.4	-	1,734.1	272.4	-
7	СХД	3,467.2	520.5	-	9,321.9	1,399.2	-
8	БНД	668.4	105.1	-	1,439.6	220.9	-
9	НД	696.7	104.6	-	1,880.2	285.2	-
10	БХД	29.1	4.9	-	54.8	8.7	-
Нийт		90,561.0	14,181.8	1,481.9	98,439.5	15,295.1	1,391.8

НБОГ нь нийслэлийн төрийн санд төвлөрсөн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос 2021 онд 1,481.9 сая төгрөг, 2022 онд 1,391.8 сая төгрөгийг байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар баталсан байна. Энэ нь 2021 онд зарцуулах хэмжээний 14.1%, 2022 онд зарцуулах хэмжээний 24.9% нь байна.

Харин дүүргүүд тухайн арга хэмжээний хөрөнгийг төлөвлөж, батлуулаагүйгээр 2021 онд 3,681.0 сая төгрөг, 2022 онд 9,704.9 сая төгрөгийг байгаль хамгаалах, нөхөн

²⁰ 4.1 "Сум, дүүргийн Засаг дарга нь байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийн төлөвлөгөө, зарцуулалтын тайланг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ",

сэргээх үйл ажиллагаанд зарцуулсан байна. Энэ нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4²¹ дэх заалтыг зөрчсөн байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу дүүргүүд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос тодорхой хувь хэмжээгээр байгаль хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих үйл ажиллагаанд төлөвлөж, зарцуулахаар хуульчилсан ч дээрх орлогын хэсгээс байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хувь хэмжээ өндөр тогтоогдсоноос бүрэн зарцуулах боломжгүй гэх тайлбарыг өгсөн боловч хуулийн дээрх заалттай холбоотой хувь хэмжээг бууруулах талаар холбогдох газруудад хандаагүй байна.

Дүгнэлт: Төлбөрийн орлогыг хуульд заасан хувь хэмжээний дагуу байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөж батлуулаагүй байна.

Б.2.2. Төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд төсвийг зориулалтын дагуу зарцуулсан уу?

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар байгаль хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг тодорхой заасан.

ХҮСНЭГТ №6 БАЙГАЛЬ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРЦУУЛАЛТ

		2021 он			2022 он			/сая.төг/
		Хуулиар зарцуулах хувь хэмжээ	Зарцуулсан	Зарцуулаагүй	Хуулиар зарцуулах хувь хэмжээ	Зарцуулсан	Зарцуулаагүй	
1	Нийслэл	10,500.8	1,380.5	9,120.4	5,590.2	628.4	4,961.8	
2	БГД	411.8	-	411.8	894.6	3.9	890.7	
3	БЗД	673.9	-	673.9	1,833.4	-	1,833.4	
4	ХУД	1,568.0	-	1,568.0	4,267.0	-	4,267.0	
5	СБД	205.0	-	205	523.4	-	523.4	
6	ЧД	87.4	-	87.4	272.4	1.5	271.0	
7	СХД	520.5	-	520.5	1,399.2	-	1,399.2	
8	БНД	105.1	-	105.1	220.9	12.6	208.3	
9	НД	104.6	-	104.6	285.2	623.2	285.2	
10	БХД	4.9	-	4.9	8.7	-	8.7	
	Нийт	14,181.8	1,380.5	12,801.4	15,295.1	1,269.6	14,025.5	

Нийслэлд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос НБОГ нь 2021 онд 10,500.8 сая төгрөгөөс 1,380.5, 2022 онд 5,590.2 сая төгрөгөөс 628.4 сая төгрөг буюу нийтдээ 16,091.0 сая төгрөгийг байгаль хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулахаар баталснаас 2,008.9 сая төгрөг буюу 12.48%-ийг зарцуулсан гэж тайлагнасан байна.

Дээрх хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг тодруулбал ЗГ-ын болон НЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, “Төрөөс ойн талаар баримтлах бодлого”-ын баримт бичгүүдэд нийцүүлэн байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг гүйцэтгэсэн байна.

²¹ 13.4.Энэ хуулийн 13.1-д заасан төлбөрийн орлогоор санхүүжүүлж хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, сум, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

Дүүргүүд 2021 онд 3,681.2 сая төгрөг зарцуулаагүй, 2022 онд 9,704.8 сая төгрөгөөс 641.2 сая төгрөг буюу 4.8%-ийг БГД, ЧД, БНД, БХД-үүд зарцуулсан байна.

БГД, ЧД, БНД-үүд булгийн эхийг хашиж, хамгаалах, мод тарих зэргээр зориулалтын дагуу зарцуулж, харин НД 2022 онд “Цэцэрлэгжүүлэлтийн алба” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлсэн гэж тайлагнасан нь ЗГ-ын 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.3²²-т заасныг зөрчиж байгалийн нөөц ашигласны төлбөрөөс орлогоос орон нутгийн төсвийн суурь зарлагыг санхүүжүүлсэн байна.

Дүүргүүд байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасан тодорхой хувийг байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахгүй байгаа нь тус хуульд байгалийн нөөц ашигласны орлогоос байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулах хувь хэмжээ өндөр учраас жилийн урсгал төсөвт нөлөөлдөг гэх тайлбарыг өсгөн.

Байгалийн нөөц ашиглах төлбөрийн орлогын байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулах хуульд заасан хувь хэмжээ, дүүргүүдийн жилийн төсвийн эзлэх хувийг ойролцоогоор тооцож үзвэл:

**ХҮСНЭГТ № 7 БАЙГАЛЬ, ХАМГААЛАХ НӨХӨН СЭРГЭЭХЭЭР ХУУЛИЙН ДАГУУ ЗАРЦУУЛАХ ХУВИЙГ
ДҮҮРГИЙН ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГОЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

		2021 он			2022 он			/сая.төг/
		Төсвийн нийт орлого	Байгаль хамгаалах, нөхөн сэргээхээр зарцуулах дүн	Төсөвт эзлэх хувь	Төсвийн нийт орлого	Байгаль хамгаалах, нөхөн сэргээхээр зарцуулах дүн	Төсөвт эзлэх хувь	
1	Нийслэл	819,921.0	10,500.8	1.3	482,043.8	5,590.2	1.16	
2	БГД	104,669.4	411.8	0.4	168,685.8	894.6	0.53	
3	БЗД	151,484.3	673.9	0.4	232,889.4	1,833.4	0.79	
4	БНД	24,238.6	105.1	0.4	12,582.4	220.9	1.76	
5	БХД	6,537.0	4.9	0.1	5,247.5	8.7	0.17	
6	СБД	142,884.2	205	0.1	301,045.5	523.4	0.17	
7	СХД	127,726.4	520.5	0.4	69,633.4	1,399.2	2.01	
8	НД	24,847.3	104.6	0.4	10,395.2	285.2	2.74	
9	ХУД	75,872.7	1,568.0	2.1	237,830.6	4,267.0	1.79	
10	ЧД	66,840.8	87.4	0.1	156,548.1	272.4	0.17	
Нийт		1,545,021.7	14,181.8	0.9	1,676,901.7	15,295.1	0.91	

Хүснэгтээс харвал дүүргүүдийн жилийн төсвийн нийт орлого нь 1,194.9 тэрбум төгрөг бөгөөд үүнээс байгалийн нөөцийн орлогоос байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах дүн нь жилийн төсвийн дунджаар 0.81%-ийг эзэлж байна.

Дүгнэлт: Төлбөрийн орлогоос байгаль, хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд зарцуулаагүй байна.

²² 3.3 “Энэ журмын 3.1-д заасан нөхцөл, хязгаарыг хангаагүй тохиолдолд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоор орон нутгийн төсвийн суурь зарлагыг санхүүжүүлэхгүй”

БҮЛЭГ В. БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙН, НӨХЦӨЛ БАЙДАЛД ТОХИРОХ АРГА ХЭМЖЭЭ АВЧ БАЙНА УУ?

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд орон нутгийн зүгээс дүн шинжилгээ хийж, нөхцөл байдалд тохирох арга хэмжээг аваагүй, хуулийн талаар ойлголтгүй байна.

В.1. Хуулийн хэрэгжилтийн тайлагнал, мэдээллийн сан үнэн зөв илэрхийлэгдэж, төрийн байгууллагуудын уялдаа холбоо оновчтой байна уу?

Хуулийн хэрэгжилтийн тайлагнал хангалтгүй, журмын дагуу тайлагнаагүй, мэдээллийн сан дутуу, буруу илэрхийлсэн, төрийн байгууллагын уялдаа холбоо хангалтгүй байна.

В1.1 Хуулийн хэрэгжилтийн тайлагнал, мэдээллийн сан бүрдүүлэлт, ил тод байдал хангагдсан байна уу?

ЗГ-ын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 4.1²³-т заасны дагуу дүүргийн ЗД нар 2021 онд НБОГ-т тайлан, мэдээ ирүүлээгүй байна.

Мөн НБОГ нь тус журмын 4.2²⁴-т заасан хугацааг хоцроож БОАЖЯ-д байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийн төлөвлөгөө, зарцуулалтын тайланг хүргүүлсэн байна.

НБОГ-аас дүүргүүдийн ЗД нарт 2022 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг БНАТ-7, БНАТ-8 маягтын дагуу ирүүлэх 01/123 дугаартай албан бичгийг 2023 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр хүргүүлсэн байна. Албан бичгийн дагуу БЗД, ЧД, БНД-үүд ирүүлж, бусад дүүргүүд ирүүлээгүй буюу тайлагнаагүй байна.

Журмын дагуу дүүргүүд мэдээллийн санд байгалийн нөөц ашигласны орлого бүрдүүлэлтийг тайлагнахдаа СБД болон БГД хоосон буюу орлого төвлөрүүлээгүйгээр, зарцуулалтын хэсгийг БХД, ХУД, СБД, СХД огт тайлагнаагүй байна. Нийслэлийн төрийн сан, НБОГ-аас ирүүлсэн дүүргүүдийн байгалийн нөөц ашигласны орлого, зарцуулалтын талаарх тоон мэдээллүүд болон хуулийн хэрэгжилтийн талаар мэдээллийн санд оруулсан тайлангууд хоорондоо зөрүүтэй байна.

Мөн НБОГ нь 2022 онд байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэлт, зарцуулалтыг тайлагнахдаа журамд заасан маягтын дагуу тайлагнаагүй, хялбаршуулсан тайлангийн маягт зохион тайлагнасан байна.

Дүүргүүд байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, түүнд холбогдох журмын талаар ойлголт муу, мэдээлэл дутмаг байгаагаас хуулийн хэрэгжилтийн тайлагнал хангалтгүй байна.

Дүгнэлт: Хуулийн хэрэгжилтийн тайлагнал, мэдээллийн сан бүрдүүлэлт, ил тод байдал хангалтгүй байна.

²³ 4.1 “Сум, дүүргийн Засаг дарга нь байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийн төлөвлөгөө, зарцуулалтын тайланг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ”,

²⁴ 4.2 “Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага нь энэхүү журмын 4.1-д заасан төлөвлөгөө, тайланг нэгтгэн боловсруулж жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэж

В1.2 Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хамтын ажиллагаа, уялдаа холбоо үр дүнтэй байна уу?

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6-д заасны дагуу Туул голын сав газрын захиргаанаас 2021, 2022 онуудад 67 иргэн, ААНБ-д ус ашиглуулах дүгнэлт гаргасан боловч НБОГ-тай мэдээлэл солилцоогүй улмаас 8 иргэн, ААНБ-тай гэрээ байгуулсан.

Нийслэл, дүүргийн төрийн сангууд нь НБОГ болон сав газрын захиргаа, Нийслэлийн татварын газар болон дүүргүүдийн татварын хэлтсээс ус ашиглах дүгнэлт гаргуулсан болон төлбөрийн үлдэгдэлтэй иргэн, ААНБ-ын мэдээллийг солилцоогүй төрийн байгууллага хоорондын ажлын уялдааг хангаагүйгээс Нийслэлийн хэмжээнд хэчнээн байгалийн нөөц ашиглагч иргэн, ААНБ байгаа нь тодорхойгүй байна.

Мөн Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу байгалийн нөөц ашигласны төлбөрийн үлдэгдэлтэй ААНБ-ын мэдээлэл холбогдох газруудад байхгүй, дүүргийн татварын хэлтэс ногдуулалт, хяналт хэрэгжүүлдэг шалтгаанаар төлбөрийн орлогын үлдэгдлийг бүртгэж тооцоо нийлээгүй байна.

Аудитаар нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсээс байгалийн нөөц ашиглагчдын мэдээллийг авч шаардлагатай тоон мэдээллүүдэд дүн шинжилгээ хийх шаардлагатай байсан ч нийслэлийн татварын газраас Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийг 13.2²⁵-т заасан үндэслэлээр мэдээлэл өгөхөөс татгалзсан учир дүн шинжилгээ хийх боломжгүй байна.

Мөн НБОГ-аас 2021, 2022 онд ус ашиглах дүгнэлт гаргасан иргэн, ААНБ-ын мэдээллийг гаргаж өгөөгүй бөгөөд, НД-т 35 дүгнэлт гаргасан ч 30 иргэн, ААН-тэй гэрээ хийж, 5 иргэн, ААН-г орхигдуулсан, бусад дүүргүүдэд дүгнэлтийн дагуу зөвшөөрөл олгож гэрээ байгуулаагүй байна.

Дүүргүүд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмын дагуу тайлагнахдаа мэдээллийг дутуу, буруу бөглөх, түүнчлэн НБОГ нэгтгэж тайлагнахдаа дүүргүүдийн мэдээллийг орхигдуулан тайлагнасан.

Зөрчлүүдийн шалтгаан нөхцөлөөс харахад Нийслэлийн байгууллагуудын ажлын уялдаа холбоогүйгээс байгалийн нөөц ашиглагчдын мэдээлэл байхгүй, холбогдох газруудын дүгнэлтэд үндэслэн зөвшөөрөл олгож гэрээ байгуулаагүй, байгалийн нөөц ашиглах болон зарцуулалтыг дутуу болон буруу тайлагнаж байна.

Дүгнэлт: Төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоо хангалтгүй байна.

²⁵ 13.2.Татварын алба, татварын улсын байцаагч, татварын албаны бусад ажилтан болон татварын албанд ажиллаж байсан этгээд, татварын албаны хэрэгжүүлэх нийтлэг үйл ажиллагаанд хөндлөнгийн гэрчээр оролцсон хүн нь албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн татвар төлөгчийн мэдээллийн нууцыг хадгалах үүрэгтэй бөгөөд доор дурдсан албан тушаалтанд татварын албаны даргын шийдвэрээр танилцуулж болно:

В.2. Хуулийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээг хийж үр дүнг дүгнэсэн үү?

Нийслэлд хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийгдээгүй байна.

В.2.1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн байгууллага нь байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт, шинжилгээ хийж, үр дагаврыг үнэлсэн үү?

ЗГ-ын 2014 оны 43 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах” /ЗГ-ын 2022 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болсон/ журмын 4.3²⁶ дах заалт болон ЗГ-ын 2022 оны 02 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан тус журмын 4.6²⁷-д зааснаар байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт, шинжилгээ хийх чиг үүрэг нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэгт хамааралтай байна.

Нийслэл, дүүргийн ИТХ-аас 2021, 2022 онуудад байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөж хэрэгжилтийг хангуулж ажиллахыг төрийн сангуудад даалгасан ч төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Мөн дүүргүүд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан батлуулж, зарцуулалтад хяналт тавих чиглэлээр арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Дүгнэлт: Нийслэлд байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт, шинжилгээ хийж, үр дагаврыг үнэлээгүй байна.

В.2.2 Нутгийн өөрөө удирдах байгууллагаас хуулийн хэрэгжилтэд хяналт хийж үр дүнг хангасан уу ?

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1²⁸, 17 дугаар зүйлийн 17.1.1²⁹-т тус тус зааснаар нийслэл, дүүргийн ИТХ нь нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний төсөв баталж, биелэлтэд хяналт тавих чиг үүрэгтэй байна.

Нийслэлийн БГД, БЗД, БНД, БХД, СБД, ХУД, НД-үүд хуульд заасан чиг үүргийн дагуу 2021, 2022 онуудад хяналт хэрэгжүүлээгүй, харин СХД 2021 онд, ЧД 2022 онд хяналт хэрэгжүүлсэн байна. СХД, ЧД хяналт хэрэгжүүлсэн байдлыг авч үзвэл:

²⁶ 4.3. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэлийн байгалийн нөхөн сэргээгдэх нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад жил бүр санхүүгийн дотоод аудит, хяналт-шинжилгээ хийнэ.

²⁷ 4.6. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэл, сум, дүүргийн байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад жил бүр санхүүгийн дотоод аудит, хяналт-шинжилгээ хийнэ.

²⁸ 16.1.1 /нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих;

²⁹ 17.1.1 /нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих;

СХД-ийн ИТХ-ийн тэргүүлэгчдийн 2021 оны 11 сарын 01-ны А/43 тогтоолоор ажлын хэсэг байгуулж түгээмэл тархацтай ашигт малтмал болон байгаль орчныг хамгаалах тухай хууль, журмын хэрэгжилтийг хангуулж ажиллах талаар хяналт шалгалт хийсэн байна.

ЧД-ийн ИТХ нь 2022 онд хурлын дэргэдэх “Ногоон хөгжил, газрын харилцааны хороо”-оор дамжуулан

- Чингэлтэй хайрхны ойжуулалт, булаг, шандын хамгаалалтын үйл ажиллагаатай танилцах;
- Дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж талбайн ногоон байгууламжийн арчлалт, хамгаалалт, байгаль хамгаалал, нөхөн сэргээх чиглэлээр хийж хэрэгжүүлж буй ажлын явц, байдалтай танилцах чиглэлээр хяналт шалгалт хэрэгжүүлсэн гэх боловч хяналт шалгалт хийсэн холбогдох баримт материал байхгүй байна.

Нийслэл, дүүргийн ИТХ-аас хуулийн хэрэгжилттэй холбоотой хяналт шалгалт хийгээгүй шалтгаан нөхцөлийг тодруулахад ИТХ нь хяналт шалгалт хэрэгжүүлэх чиг үүрэггүй гэсэн тайлбарыг өгч байна.

Дүгнэлт: Нийслэл, дүүргийн ИХТ нь хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль нь холбогдох хууль, журмуудтай нийцээгүй, хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтны чиг үүрэг давхардсан, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангалтгүй байна.
2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлт нийслэлийн хэмжээнд 95.8%-тай байгаа ч тухайн орлогын тодорхой хувийг байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулаагүй, хэрэгжилтийг тайлагнаагүй холбогдох журмыг мөрдөж ажиллаагүй.
3. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, Нийслэл, дүүргийн ИТХ, ЗДТГ болон холбогдох байгууллага, хэлтсүүд хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, нөхцөл байдалд тохирох арга хэмжээг аваагүй, хуулийн талаарх ойлголт муу байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт:

1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн холбогдох заалтуудыг бусад хууль, журмуудтай нийцүүлэх, хуульд заасан хэрэгжүүлэгч байгууллага, албан тушаалтны чиг үүргийн давхардлыг арилгах хуульд өөрчлөлт оруулах саналыг холбогдох байгууллагад хүргүүлэх;

НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Д.Сумъяабазар/-д:

1. Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх, байгалийн нөөц ашиглалттай холбоотой бодлогын хэрэгжилтийг орон нутгийн түвшинд сайжруулах талаар арга хэмжээ авч, үр дүнг үнэлж хэвших;
2. Нийслэлийн хэмжээнд байгалийн нөөц ашигласны төлбөрөөс орох орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, төлбөрийн орлогын зохих хувийг байгаль хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих үйл ажиллагаанд үр дүнтэй зарцуулж хэвших;
3. Нийслэл, дүүргийн хэмжээнд холбогдох байгууллагуудаас байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуультай холбоотой санал авч хуульд өөрчлөлт оруулах, бусад эрх зүйн акттай нийцүүлэх талаар холбогдох дээд байгууллагад санал хүргүүлэх.

Дүүргүүдийн ИТХ, ЗД-д:

1. Дүүргийн хэмжээнд 2023 оны байгалийн нөөц ашигласны төлбөрөөс орох орлогын төлөвлөгөөг байгалийн нөөц ашиглагч иргэн, ААНБ бүрээр оновчтой төлөвлөж, гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлэх, орлогын хуульд заасан зохих хувийг байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулж, хийсэн ажлын тайланг ирүүлэх;

Нийслэлийн Байгаль орчны газарт:

1. Ус ашиглах дүгнэлт гаргасан иргэн, ААНБ-тай нөхөн гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж, хийсэн ажлын тайланг ирүүлэх;
2. Сав газрын захиргаа, дүүргүүдийн ЗДТГ, төрийн сан, Газар зохион байгуулалтын алба, Татварын хэлтэс, Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан нэгжүүдтэй ажлын уялдаа холбоог сайжруулж, нийслэлийн хэмжээнд байгалийн нөөц ашиглагч иргэн, ААНБ-ыг бүртгэж, нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлж, дүүрэг тус бүрээр тайлагнан ирүүлэх;
3. “Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-д заасан батлагдсан маягтын дагуу 2023 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийг дүүрэг тус бүрээр тайлагнаж, баталгаажсан тайланг ирүүлэх;

Нийслэлийн Татварын газарт:

1. Нийслэлийн хэмжээнд байгалийн нөөц ашигласны төлбөрөөс орох орлогын ногдуулалт, төлөлтөд хяналт хэрэгжүүлж, төлбөр ногдуулагч сав газрын

захиргаа, НБОГ, дүүргүүдийн ЗДТГ, төрийн сан, Газар зохион байгуулалтын алба, Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан нэгжүүдтэй хамтын ажиллагааг сайжруулж сар, улирал бүр мэдээлэл солилцож, хагас, бүтэн жилээр тооцоо нийлж ирүүлэх;

Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албанд:

1. Нийслэл, дүүргийн хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар газрын төлбөр төлөгчдийн судалгааг шинэчлэн гаргаж, шинээр газар эзэмшигч, ашиглагч иргэн, ААНБ-ыг газрын төлбөр төлөгчдийн судалгаанд бүрэн хамруулсан эсэхэд хяналт хэрэгжүүлж, хийсэн ажлын тайланг ирүүлэх;
2. 2020, 2021 оны газрын төлбөрийн орлогын төлөвлөөний гүйцэтгэлийг Нийслэлийн Татварын газар, дүүргүүдийн Татварын хэлтэстэй тооцоо нийлж, акт үйлдэн газрын төлбөрийн үлдэгдэлтэй иргэн, ААНБ-ын мэдээллийг гаргаж, төлбөр барагдуулах чиглэлээр арга хэмжээ авч хийсэн ажлын тайланг ирүүлэх;